

С.Нямжав- ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн тактикийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

ОРЧИН ҮЕИЙН ГАРДАН ТУЛААНЫ СУРГАЛТЫН ЧИГ ХАНДЛАГА

Хураангуй. Орчин цагт хувь хүн өөрийн аюулгүй байдлаа хангаж, чаддаг чадамжтай байх хэрэгцээ, шаардлага үүсэн бий болсон. Энэхүү хэрэгцээг хангахад зориулсан төрөл бүрийн бие хамгаалах урлаг, спортын сургалтыг явуулдаг хувийн эвсэл холбоо, байгууллагууд ихээр гарч ирж, мөн тухайн чиглэлийн судалгаа, шинжилгээний ажил ч эрчимтэй хөгжиж байна.

Олон улсад хувь хүний мэргэжил, боловсрол, нас, хүйсийн онцлогийг харгалзан түүнд тохирсон аюулгүй байдлаа хангах олон төрлийн гардан тулааны цогц систем үүсэн бий болжээ. Гардан тулааны эдгээр цогц системүүд нь хувь хүний бие, сэтгэл зүй, ажил мэргэжлийн онцлогт тулгуурсан олон төрлүүдтэй.

Монгол улсын төрийн тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагын сургалт, бэлтгэлээр явуулж байгаа гардан тулааны нь дэлхий нийтийн жишигтэй адил боловч, албан хаагч, суралцагчдынхаа бие, сэтгэцийн онцлогийг тооцоогүй, орчин үеийн мэргэжлийн бие хамгаалах арга техникийн бус, спортын, урлагийн шинжтэй байна. Мөн эвсэл холбоод ч гэсэн гардан тулааны спорт, урлагийн чиглэлээр илүү түлхүү хөгжүүлж ирсэн. Иймд би өгүүлэлдээ орчин үед гадаад улс оронд өөрийгөө хамгаалах мэргэжлийн гардан тулааны систем хэрхэн дэлгэрч, хөгжиж байгаа, Үүнээс хамгийн үр дүнтэй сургалтын тогтолцооны талаар судалж, өөрийгөө хамгаалах чадвар, чадамжийг хэрхэн дээшлүүлэх боломж байгаа талаар судалгаа, дүн шинжилгээ хийлээ.

Түлхүүр үг. Бие хамгаалах, гардан тулаан, сургалт, Крав Мага.

Оршил

Гэмт халдлагаас иргэдийг хамгаалах нь зөвхөн төрийн үүрэг, оролцоо бус харин хувь хүн өөрөө өөрийгөө хамгаалах нь өнөөгийн нийгмийн шаардлага, хамгийн боломжит, үр дүнтэй бөгөөд оновчтой шийдэл болохыг харуулах, гадаад улс орон дахь гардан тулааны сургалтын олон талт хэлбэрүүдийг сонгон өөрийн оронд нэвтрүүлэх зарим боломжийг судалж, нээн илрүүлэхэд зорилгоор энэхүү өгүүллийг бичлээ.

Гардан тулааны сургалт, бэлтгэлийн талаар олон эрдэмтэн, судлаач судалгаа явуулж, энэ чиглэлээр биеэ хамгаалах систем боловсруулсан байдаг. Судалгааны шинжилгээний ном бүтээл туурвисан эрдэмтэн, судлаачдын дотод Б.Бат байлдааны самбо; Б.Батжав цагдаагийн алба хаагчийн тусгай бэлтгэлийн онол, тактик; Д.Дашмягмар албаны тусгай бэлтгэлжилт; Д.Отгонбаяр үндэсний тулааны урлаг; Г.Пүрэв-Очир самбочдын дасгалжуулалт; Л.Тод, В.Чулуунбат халз тулааны урлаг; З.Чулуунхүү, Ч.Эрдэнэчулуун бие хамгаалах тусгай чадамж; В.Жавхланцогт гардан тулааны арга зүй; С.Нямжав гэрээт харуул хамгаалалтын ажилтан хүч, техник, хэрэгсэл хэрэглэх арга зүй;

С.Хаянгарваа гардан тулаан, мөн хууль сахиулах ба цэргийн сургуулиудад бие хамгаалах сургалтыг явуулж ирсэн онцлог, хөгжүүлэх боломжийг судлан нэг сэдэвт зохиол туурвисан. Гэхдээ улс орны аюулгүй байдал иргэдийн амар тайван амьдралын төлөө үүрэг гүйцэтгэж буй байгууллагын алба хаагчдын биеэ хамгаалах талаар явуулж байгаа сургалт, бэлтгэлжилт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй үр ашиг багатай байна. Мөн иргэдийн биеэ хамгаалах чадамжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн тулааны олон төрөл, урсгалууд гарч ирж байгаа бөгөөд энэ чиглэлийн сургалтыг явуулдаг олон байгууллага, клуб нээгдэн ажиллаж байгаа боловч эдгээр нь орчин үеийн сургах зүй (дидактикийн)-н арга технологийг тэр бүр хэрэглэж чадахгүй байна.

Үндсэн хэсэг

Гардан тулааны маш олон төрөл, урсгал, хэв маягууд байдаг. Эдгээр гардан тулааны төрлөөс бокс гэх мэт нийтлэг спортоор хичээллэдэг эсэх, эсвэл каратэ гэх мэт уламжлалт тулааны урлагт сурдгаас үл хамаарч, дэлхий нийтэд хамгийн үр дүнтэй бие хамгаалах аргын талаар маргаан их гардаг.

Судлаачид бодит амьдралд зэвсэг хэрэглэхгүй, ямар ч дүрэмгүйгээр биеэ хамгаалах хамгийн үр дүнтэй шилдэг аргуудыг судалж үзсэн байна. Эдгээр 10 төрлийг гардан тулааны шилдэг төрөл гэж үзэн доорх байдлаар эрэмбэлсэн байна. Үүнд:

“Гардан тулалдааны шилдэг 10 төрөл

1. Крав Мага
2. Панкратион
3. Байлдааны самбо
4. ММА
5. Бөхийн барилдаан
6. Бразилийн жиу-жицу
7. Летвей (Бирмийн бокс)
8. Жүдо
9. Муай Тай
10. Бокс”

Жагсаалтын 1-д “Крав Мага” гэгдэх цэргийн өөрийгөө хамгаалах систем орсон байна. Энэхүү систем нь сүүлийн үед дэлхийн өнцөг булан бүрд хамгийн үр дүнтэй өөрийгөө хамгаалах арга гэж үзэж, маш хурдацтай түгээн дэлгэрч, хөгжиж байна.

“Ими Личенбелд гэх еврей гаралтай эр IDF /Израилийн өөрийгөө хамгаалах хүчин/-д 20 орчим жил ажиллах хугацаандаа өөрийгөө хамгаалах өвөрмөц аргыг боловсруулж, шилдэг цэргүүдийг бэлтгэж, Израилийн цэргийг дэлхийн элит цэргийн хүчин болгосон байна. Энэ боловсруулсан арга техник нь ямар ч сул дорой, авхаалж самбаа муутай цэрэг амжилттай сурч чадахуйц

болгож, өөрөөр хэлбэл олон жилийн хүч хөдөлмөр, дасгал сургуулилт зарцуулан сурдаг хүнд техник, хөдөлгөөний оронд хөнгөн хялбар, энгийн бөгөөд хэн ч сурч чадахуйц болгожээ.

Зөвхөн цэрэг, цагдаагийн байгууллагад төдийгүй “Крав Мага”-г иргэний хэрэгцээнд нийцүүлэн өөрчилжээ. Энэхүү арга барил нь гэмт үйлдэл, үндсэрхэг үзлээс улбаатай, эсвэл өөр бусад ямар ч нөхцөл байдалд үүссэнээс хамааралгүйгээр дайралтыг хамгийн бага хохиролтойгоор тэсэж гарах, амьд үлдэхийг хүссэн эрэгтэй, эмэгтэй, охид, хөвгүүд хэн бүхэнд тохирохоор шинэчлэн боловсруулжээ. Үүнтэй холбоотой тухайн сургалтын тогтолцооны хэлбэр, төрлүүдийн ялгаа, онцлогийг тодруулан харуулья (1-р зураг).

“1-р зураг. “Крав Мага”-гийн сургалтын хэлбэр”



Энэ системийн гол зарчим бол сургалт энгийн байх явдал юм. Учир нь мэдлэг, чадвар муутай, сул дорой залуучууд эсвэл аль хэдийн өндөр настай болсон ахмад дайчдыг сургах ёстой байсан учраас уг системийг хамгийн энгийн буюу байгалийн хөдөлгөөнийг сонгож, түүн дээр тулгуурлан арга техникийг боловсруулсан байна.

“Крав Магагийн сургалтын чухал бүрэлдэхүүн хэсэг нь олон талт байдал, өөрөөр хэлбэл мэргэшлийг

хөдөлгөөнийг ерөнхий загварт орлуулдаг.

Зорилго нь мөргөлдөөнийг хамгийн богино хугацаанд эцэслэх явдал бөгөөд түүнд хэрхэн хүрэх нь тодорхой онцлогоос хамаарна.” Жишээлбэл: Цэргийн салбарт дайснаа буудах нь хамгийн хялбар байдаг бол цагдаа, хууль сахиулах салбарт түүнийг аюулгүй болгож, албадан саатуулж, газар хэлтэст хүргүүлэх шаардлагатай. Харин энгийн иргэн эсэргүүцэл довтолгооны няцаагаад зугтах хэрэгтэй.

Гэмт халдлагаас иргэдийг хамгаалах нь зөвхөн төрийн байгууллагын үүрэг оролцоо бус харин хувь хүн өөрөө өөрийгөө хамгаалах нь өнөөгийн нийгэм дэх шаардлага, хамгийн боломжит, оновчтой шийдэл болохыг харуулах үүднээс энэхүү бие хамгаалах сургалтын системийн хэлбэрээс санаа авч, ямар агуулга, арга зүйгээр явуулбал оновчтой болохыг тодорхойлж, монгол уламжлал, шинэчлэлийг хослуулан сургалтыг явуулж болох юм.

Үр дүн: Сургалт бэлтгэлийг нэвтрүүлж, зохион байгуулан явуулснаар зөвхөн цэрэг, цагдаа гэх мэт үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн

байгууллагын алба хаагчдад бус өөрийн орны иргэдэд биеэ хамгаалах чадварыг эзэмшүүлснээр тэдний амар амгалан аюулгүй амьдрах тодорхой нөхцлийг бүрдүүлэх, мөн эрүүл чийрэг бие бялдартай, өв тэгш хүмүүжилтэй хүнийг бий болох юм.

Дүгнэлт

Зарим улс орны иргэдийнхээ эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлаа хангахын тулд явуулж буй биеэ хамгаалах гардан тулааны сургалтын туршлагыг бүтээлчээр судалж, өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлэх нь зүйтэй. Урлаг, спортын шинжтэй гардан тулааны сургалт манай улсад амжилттай хөгжиж байна. Харин иргэн болоод алба хаагчид зориулан аюулгүй байдлаа хангахад чиглэгдсэн мэргэжлийн гардан тулааны сургалт сайн хөгжөөгүй байгаа ба төрийн бодлогоор сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, нээлттэй, тасралтгүй, шаталсан хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлагатай байна. Энэ сургалт нь спортын сургалтаас бодит тулааны сургалт уруу, заалны сургалтаас бодит орчны сургалт уруу чиглэгдсэн байх хэрэгтэй гэж үзэж байна.

Санал

Зааж буй хичээлийн арга техникт нь зөвхөн спортын бус бодит амьдралд тулгуурласнаас дараах санал байна. Үүнд:

- Нударга, дал, тохой, толгой, хөл, өвдөг болон биеийн аль ч хэсгээр янз бүрийн байдлаар цохих, хатгах, өшиглөх, түлхэх, мөргөх, шидэх, боох зэрэг үйлдлүүд орно. Мөн мод, хутга, гар бууны эсрэг хэрхэн яаж ажиллах бөгөөд тэдгээр зүйлээр хэрхэн тулалдах аргыг хүртэл боловсруулсан байна.

- Янз бүрийн эрсдэлтэй нөхцөл байдалд гудамжинд, орцонд, машинд, хэд хэдэн өрсөлдөгчийнхөө эсрэг жүжиглэх, тоглох. Тэдэнд тулааны хэрхэн яаж салгах, охид эмэгтэйчүүд эсвэл хүүхдүүдийг хамгаалах талаар сургахаас гадна хүүхэд, охид, эмэгтэйчүүд нь хүчирхийлэгч эсвэл дээрэмдэгч, хулгайчтай хэрхэн тэмцэхэд сургах. Өөрөөр хэлбэл тодорхой төрлийн сургалтад чиглэгдэнэ. Жишээлбэл: Хутга тулган эд зүйлийг дээрэмдэх, түрийвч болон утас булаах гэх мэт үйлдлийн эсрэг чиглэгдсэн техникийг боловсруулж, энэ чиглэлд тулгуурласан техникийг сонгон заана.

- Мөн хүнд хэцүү орчинд ажиллаж сурахын тулд суралцагчдыг тогтмол стресст оруулах. Жишээлбэл: Тэднийг хашхирч, татаж, түлхэх эсвэл нүдийг нь боох гэх мэт.

- Сэтгэл зүй, зан үйлийн хувьд өөрчлөх, төлөвлөх, цагийн байдлыг үнэлэх чадварт анхаарал хандуулах. Жишээлбэл: Олон хүн тан руу чиглэн явж байгаа бол гудамжны эсрэг талд гарах, танихгүй хүмүүстэй машинд цуг суухгүй байх гэх мэт тактикийн талаас анхаарах мэдлэг эзэмшүүлнэ.

Эх сурвалжийн жагсаалт

1. Хаянгарваа С. “Монгол улсын хууль сахиулахын их сургуульд гардан тулааны хичээлийг явуулжирсэн уламжлал, стандарт, тавигдах шаардлага”, “Хууль сахиулах, батлан хамгаалах байгууллагын алба хаагчдад гардан тулааны урлагийн сургалтыг заах онцлог” хурлын илтгэлүүдийн эмхтгэл, 2015он, х5-12
2. Хаянгарваа С. “Цэрэг, цагдаагийн сургуулиудын бие хамгаалах сургалтыг хөгжүүлэх зарим боломжийг судалсан нь, дис, 2011 он
3. Хаянгарваа С. “Цэрэг, цагдаагийн сургуулиудын бие хамгаалах сургалт, түүний боловсронгуй болгох асуудал”, 2009 он
4. Хаянгарваа С. ‘Гардан тулаан’, 2021 он
5. Батжав Б. “Иргэний крав мага”, 2019 он
6. Батжав Б. “Иргэний Крав Мага” сургагч багшийн гарын авлага. УБ., 2019 он
7. Батжав Б. “Цагдаагийн албан хаагчийн биеийн хүч хэрэглэх тусгай бэлтгэлийн сургалтын онолын үндэс”, 2014 он
8. Жавхланцогт В. ‘Гардан тулалдааны урлагт суралцах арга зүйн үндэс”, 2010 он
9. Чулуунхүү З., Эрдэнэчулуун Ч. “Бие хамгаалах ур ухаан, тусгай чадамжаа дээшлүүлэе”, 2010 он
10. Хасбаатар С. “Тусгай мэх”, 2009 он
11. Тарас А.Е. “Боевая машина-1”, Минск, 2014 г
12. Хаянгарваа С. “Монголд бие хамгаалах сургалтыг явуулж ирсэн уламжлалын асуудал”, Хил судлал, 2010 он, х39-44
13. Нямжав С. ‘Гэрээт харуул хамгаалалтын ажилтан хүч, техник, хэрэгсэл хэрэглэх арга зүй”. 2014 он
14. Бат Б. “Байлдааны самбо”, 1988 он
15. Баяраа Г.Хамгаалалт, 1990 он
16. Тод Л., Чулуунбат В. “Халз тулалдааны урлаг”, 1995 он
17. Дашмягмар Д. “Албаны тусгай бэлтгэлжилт”, 2003 он
18. Отгонбаяр Д. “Монгол цэргийн эрдэм буюу үндэсний тулааны урлаг”, 1998он
19. Петров М. “Техника дзю-дзюцу”. Минск, 2015 г